



САНТ СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМ-д

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2020.07.28 № 309

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.3, 37.5 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох тус сумын Монгол Ардын намаас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн 2020 оны ээлжит сонгуульд оролцох сумын Монгол Ардын нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцүүлэн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт аймаг дахь Төрийн аудитын байгууллагад ирүүлж, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль 37 дугаар зүйлийн 37.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох сумын Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ “Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020” Тулгуур зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020” Нийцлийн аудитын зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020”, Өвөрхангай аймгийн нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, “Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг”, Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

015030593


## Дүгнэлт

Сумын Монгол Ардын намын “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгууль”-д оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын заалт, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр / .... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сумын сонгуулийн хороонд .

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.ЛАМААЧИН

## 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД САНТ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМААС ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

### 1. ХҮНИЙ ХӨГЖИЛ-ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ

1.1.1. Эрүүл мэндийн төвийн шинэ барилга барьж байгуулна.

Эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ

1.1.2. Эрүүл мэндийн төвийг хатуу зөөлөн эдлэлээр хангана.

Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал, хүртээмжийг сайжруулна.

1.1.3. СӨББ-ын урлаг заал шинээр барьж, хөгжим техник хэрэгсэлээр хангана.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ.

1.1.4. СӨББ-ыг тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангана.

Сургуулийн өмнөх боловсрол нь хүүхдийн төлөвшил, хөгжлийн суурь үе хэмээн үзэж цэцэрлэгийн үйлчилгээний болон сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн цогц үйл ажиллагааг зохион байгуулж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангана.

1.1.5. СӨББ-ын гадна стандартад нийцсэн тоглоомын талбай барьж байгуулна.

Хүүхэд багачуудын тоглож наадангаа хөгжих стандартад нийцсэн таатай орчинг бүрдүүлнэ.

1.1.6. СӨББ-ын багш нарыг компьютер техник хэрэгслээр хангана.

Цэцэрлэгийн багшийн ажлын чанарыг сайжруулах, сургалтын үйл ажиллагаанд бэлдэх, өөрийгөө хөгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

1.1.7. Ерөнхий боловсролын сургуулийн урлаг заалыг тохижуулж, хөгжим техник хэрэгсэлээр хангана.

Сургуулийн дотуур байр, спортын болон урлагийн заалыг тохижуулж, сургалтын байгууллагын орчны стандартыг ханган хүүхэд, хэрэглэгчдэд ээлтэй болгох ажлыг үе шаттайгаар төлөвлөж хэрэгжүүлнэ.

1.1.8. ЕБС-ийн гаднах спортын талбайг тохижуулна.

Сургуулийн гаднах спортын талбайг тохижуулж, сургалтын байгууллагын орчны стандартыг ханган хүүхэд, суралцагчдад ээлтэй нөхцөл бий болгоно.

1.1.9. Сумын төвд Спорт заал шинээр барина.

Сургалтын байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлж,



сумын нийт иргэд спортоор хичээллэх чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх таатай нөхцөл бий болгоно.

## **2. ХҮНД ЭЭЛТЭЙ АМЬДРАХ ОРЧИН-БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ**

2.1.1. Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу шинэ бүсэд төлөвлөж буй Хаус хороололруу инженерийн шугам сүлжээ татаж дэд бүтэц бий болгоно.

Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээнд холбогдсон амины орон сууц, хаус хороолол шинээр байгуулж, иргэдийн ая тухтай эрүүл орчинд амьдрах боломжийг бүрдүүлнэ.

2.1.2. Гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд үе шаттайгаар холбоно.

Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу гэр хорооллын гудамжийг инженерийн шугам сүлжээнд үе шаттайгаар холбон иргэдийн ая тухтай эрүүл орчинд амьдрах боломжийг бүрдүүлнэ.

2.1.3. Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж байгуулна.

Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлж, иргэдийн эрүүл, эко орчинд амьдрах, чөлөөт цагаа зөв өнгөрөөх боломжийг бүрдүүлнэ.

2.1.4. ЗДТГ-ын шинэ барилга барина.

Төрийн албан хаагчийн нэр хүндийг дээшлүүлж, ажиллах ая тухтай нөхцөл байдлыг бүрдүүлэх, нийгмийн баталгаагаар хангах зохистой тогтолцоог төлөвшүүлнэ.

2.1.5. Улаан-Овоо багийн төвийн шинэ барилга барина.

Төрийн албан хаагчийн нэр хүндийг дээшлүүлж, ажиллах ая тухтай нөхцөл байдлыг бүрдүүлэх, иргэд үйлчлүүлэгчдэд төрийн үйлчилгээг чанар, хүртээмжтэй хүргэнэ.

2.1.6. Сумын төвд 1 км хутуу хучилттай зам тавина.

Орон нутагт төрөөс үзүүлэх нийгмийн үйлчилгээний стандарт, нормативыг хангах замаар сумаас гадагшаа чигэлсэн шилжилт хөдөлгөөнийг сааруулна.

2.1.7. Эрчим хүчний хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

Сумын төвийн эрчим хүч хэрэглэгчдийг найдвартай эрчим хүчээр хангах талаар анхаарч хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

2.1.8. Гэр хороололыг эко жорлонгоор хангана.

Цэвэрлэх байгууламж, гэр хорооллын ариун цэврийн байгууламжийн лагийг байгальд ээлтэй аргаар устгах, сумын төвийн иргэдийг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн орчинд амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

2.1.9. Сант сумын төвийн угтах, үдэх хаалга барьж байгуулна.

Сумын ИТХ-ын тогтоолоор "Угтах, үдэх халганы зураг төсөвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн. Хувийн хөрөнгө оруулалт, хандив тусламжаар угтах, үдэх хаалгыг барьж байгуулна.

2.1.10. Сумын хэмжээнд хогны менежментийг сайжруулна.



Хог хаягдлын цогц менежмент хэрэгжүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, дахин боловсруулах, ашиглах загвар төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, ногоон байгууламж бүхий талбайг нэмэгдүүлнэ.

2.1.11. Сумын хэмжээнд үүрэн холбооны сүлжээг сайжруулна.

Мэдээлэл холбооны дэд бүтцэд холбогдоогүй алслагдсан цэгүүдийг холбосон мэдээлэл дамжуулах, солилцох сүлжээг сайжруулна.

2.1.12. Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу шинэ бүсэд наадмын тайлбай барина.

### **3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ-ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ**

3.1.1. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, малын гаралтай түүхий эд, дайвар бүтээгдэхүүн боловсруулах цех, бичил үйлдвэр байгуулна.

Бичил, жижиг, дунд үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг дэмжих, орон нутгийн түүхий эдийн нөөц боломжид тулгуурлан үйлдвэрлэл эрхлэгч ААН, иргэдийг хөнгөлттэй зээлийн бодлогоор дэмжин эдийн засгаа сайжруулах бодлого барина.

3.1.2.Талх, нарийн боовны цех байгуулна.

Эрүүл хүнсээр сумаа хангах, үйлдвэр эрхлэгч сонирхолтой иргэн, ААН-ыг зээл тусламжид хамруулан хөрөнгө оруулалтыг нь дэмжинэ.

3.1.3. Мал нядалгааны цех байгуулах

Бичил, жижиг, дунд үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг дэмжих, орон нутгийн түүхий эдийн нөөц боломжид тулгуурлан үйлдвэрлэл эрхлэгч ААН, иргэдийг хөнгөлттэй зээлийн бодлогоор дэмжин эдийн засгаа сайжруулах бодлого барина.

3.1.4. Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах гүний худаг гаргана

Байгаль экологи, бэлчээрийн даацтай уялдуулж, малын тоо, төрөл, бүтцийг тогтоож, бэлчээрийн мэрэгч амьтад, шавжтай тэмцэх, малын бэлчээр, хадлан, тэжээл, усны хангамж, хүрэлцээг нэмэгдүүлж, мал аж ахуйн эрсдэлийг бууруулна.

3.1.5. Малын тэжээлийн ургамал тариалах талбай байгуулна.

Малын бэлчээр, хадлан, тэжээл, усны хангамж, хүрэлцээг нэмэгдүүлж, мал аж ахуйн эрсдэлийг бууруулна.

3.1.6. Малын сүргийн бүтцийг сайжруулна.

Малын удам зүй, сонгон үржүүлэг, селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, үржлийн стратегийн дагуу явуулах, малын үүлдэрлэг байдал, ашиг шимийн гарц, чанарыг сайжруулна.

3.1.7. Төмс хүнсний ногоо тариалах, хүлэмжийн аж ахуй эрхлэх бааз суурийг бэлтгэн тариалалтыг дэмжинэ. /талбай, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хүлэмж гэх мэт/ Стратегийн хүнсний зориулалттай болон бусад нэр төрлийн ашигт таримлын тариалалт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, сумынхаа хэрэгцээг хангах, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж, шинэ нэр төрлийн таримлын бүтээгдэхүүн бий болгох, импортыг бууруулна.

